

Аудитын код: САГ-2017/03/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261740 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор О.Баярмаа
Утас: 261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	5
2.5	Дотоод хяналт	6
2.6	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	7
2.7	Шилэн дансны мэдээлэл	7
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар	8
2.9.2	Тайлагналын талаар	8
2.9.3	Дуусаагүй үйлдвэрлэл дансны талаар	8
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	9
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	9
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	9
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
3.1	Дуусаагүй үйлдвэрлэл дансны талаар	12
3.2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар	13
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	14
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18

1 Аудитын гэрчилгээ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.04.25 № 748

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Монгол Улсын Ерөнхий сайд Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 10-наас 2017 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор О.Баярмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Сайд, ЗГХЭГ-ын даргын 2017 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн ХЭГ/543 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Ерөнхий сайд яам, Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, энэ чиглэлээр цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд тавих хяналт, шалгалт, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явцад хийх хяналт, шинжилгээ, үр дүнд өгөх үнэлгээний үр ашгийг дээшлүүлэх, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн өмчийн хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах зэрэг үйл ажиллагааг явуулж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд дараах ажлыг эрхлэн гүйцэтгэж байна.

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудад засаглал, эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр ашгийг дээшлүүлэх, зөвлөн туслах;
- Төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалах;
- Мэдээллийн технологи, харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлэх, мэдээлэл хүртээх тэгш бус байдал, тоон ялгааг арилгах, хууль эрх зүйн тааламжтай орчныг бүрдүүлэхэд төрөөс баримтлах бодлого, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох;
- Төрийн болон хувийн хэвшлийн, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын цахим хуудас, цахим шууданг хадгалах хамгаалах, хэвийн үйл ажиллагааг хангах;
- Харилцаа холбооны технологийн салбарын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх, алслагдсан орон нутгийн хүн амд харилцаа холбооны үйлчилгээг хүргэх, харилцаа холбооны сүлжээ шинээр байгуулах, өргөтгөх, шинэчлэх;
- Ашигт малтмал, газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж тухайн санхүүгийн жилд төсөвт төлсөн татвар, төлбөр, нөгөө талаас Засгийн газар тэдгээр компаниудаас төсвөөр дамжуулан хүлээн авсан татвар, төлбөрийнхөө орлогыг тайлагнах, улмаар 2 талаас ирүүлсэн тайланг нэгтгэж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөндлөнгийн аудитор тодруулга хийж, баталгаажуулан олон нийтэд ил тодоор мэдээлэх;
- Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого, бодлогыг хэрэгжүүлэх, улсын аюулгүй байдлыг хангах, тогтвортой хөгжлийн нөхцлийг бүрдүүлэх;
- Төрийн тусгай хамгаалалт, үйлчилгээг явуулах, хамгаалалт, үйлчилгээний ажлын чанарыг дээшлүүлэх, үйлчилгээг хөнгөн шуурхай болгох;

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн

нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна үйлчлүүлэгчийн зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 7 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2016 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим зүйл заалт Сангийн яамнаас 2016 онд авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам заавартай нийцэж байна. Гэвч дараах асуудлыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дэлгэрэнгүй тусгах шаардлагатай. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлалтай холбоотой асуудал;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэртэй холбоотой асуудал;
- Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн ашиглалт, мэдээллийн аюулгүй ажиллагаатай холбоотой бодлого зэрэг болно.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашиглажээ.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Дотоод аудитын алба нь төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, санхүүгийн тайлан, Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний нэгжүүдийн үйл ажиллагаанд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, байгууллагын үйл

ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлж, эрсдэлийн удирдлагаар хангах ажлыг эрхлэн гүйцэтгэж байна.

Дотоод аудитын алба 2016 онд Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийжээ.

2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Улсын төсвөөс 166,364.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөн баталсан ба гүйцэтгэлээр 162,227.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Мөн төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 19,658.9 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн ч, гүйцэтгэлээр 17,156.9 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 179,383.4 сая төгрөг буюу 96.4 хувьтай байгаа нь Сангийн яам улс орны эдийн засгийн хүндрэлтэй байдлын улмаас төлөвлөсөн зарим зардлын эрхийг хязгаарлах бодлоготой холбоотой 4,137.9 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас олох 2,502.0 сая төгрөгийн орлогыг дутуу бүрдүүлсэнээс шалтгаалжээ.

Ерөнхий сайдын төсвийн багцад тайлант онд 186,023.9 сая төгрөгийн төсвийг зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 179,383.4 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс бараа ажил үйлчилгээний зардал 69,086.8 сая төгрөг, татаас, урсгал шилжүүлэг 7,729.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Хөрөнгийн зардалд 102,567.0 төгрөгийг зарцуулжээ.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

1. Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)
2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн, Хагас жилээр, Улирал, Сар бүр)
3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)
4. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
5. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
6. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)
7. Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
8. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)
9. Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2016 оны байдлаар нийцлийн аудит хийхэд зөрчил дутагдал илрээгүй байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 3 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Харилцаа холбооны зохицуулах хороо, Үндэсний "Дата" төв УТҮГ зэрэг байгууллагуудын НББ-ийн бодлогын баримт бичигт “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх тухай” Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлалтай холбоотой асуудал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэртэй холбоотой асуудал, Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн ашиглалт, мэдээллийн аюулгүй ажиллагаатай холбоотой бодлогын өөрчлөлтийг тусгаагүй, байгууллагын онцлогт тохируулан шинэчлэн боловсруулалт хийгээгүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “*Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана*” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын онцлогт тохируулан шинэчлэн баталж, мөрдөж ажиллах зөвлөмж өгөх

2.9.2 Тайлагналын талаар

Ерөнхий сайдын төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайлангийн эхний үлдэгдэл нь өмнөх оны аудит хийгдсэн тайлангийн эцсийн үлдэгдлээс 4,488.1 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “*Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах*”, УСНББОУС 1-ийн 27-д “*Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой*” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайлангийн эхний үлдэгдлийн зөрүүг аудитын явцад залруулсан болно.

2.9.3 Дуусаагүй үйлдвэрлэл дансны талаар

- “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК нь “Монгол Улсын хэмжээнд интернетийн үйлчилгээг ижил үнэ тарифаар хүргэх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2016 оны 123 дугаар тогтоолоор БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн хүрээнд 45.6 сая ам.доллар буюу 113,522.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн мэдээлэл, холбооны үндсэн сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн хөрөнгийг бүртгэлд авах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2016 оны 7

дугаар сарын 21-ний өдрийн 57/04 дугаар тогтоол гарсан боловч хэрэгжүүлээгүй байна.

- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэл 31,167.4 сая төгрөг, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн дуусаагүй үйлдвэрлэл данс 13,226.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба дансанд олон жил хуримтлагдсан, бичиг баримтын бүрдэл дутуу, шилжүүлэхэд бэлэн болсон хөрөнгийг бүртгэх талаар тодорхой шийдвэрт хүрээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8-д *“Төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах”* гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Дуусаагүй үйлдвэрлэл дансанд удаан хуримтлагдсан үндсэн хөрөнгийг холбогдох байгууллагуудад шилжүүлэх арга хэмжээ авах талаар зөвлөмж өгөх.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн алдаа, зөрчлийг арилгах 5 зөвлөмжийг биелүүлж, 3 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлээгүй байна. Тус компанид өмнөх онуудад хэрэгжсэн төслүүдийн үйл ажиллагаанд эрсдэлийн аудит хийх шаардлагатай байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 162,404.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнээс 4,488.1 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 157,916.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4 зөвлөмжийг 76 хувьтай биелүүлсэн байна. Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ЗГХЭГ-ын СХОҮХ-ийн даргын 2016 оны Х/325 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлжээ. Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 146,606.5 сая

төгрөг бөгөөд түүний 1 хувь 1,466.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-д тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон Дотоод аудитын албаны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 Дуусаагүй үйлдвэрлэл дансны талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь Монгол Улсын хэмжээнд интернетийн үйлчилгээг ижил үнэ тарифаар хүргэх талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2016 оны 123 дугаар тогтоолоор БНХАУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн хүрээнд 45.6 сая ам.доллар буюу 113,522.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн мэдээлэл, холбооны үндсэн сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн хөрөнгийг бүртгэлд авах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2016 оны 7 дугаар сарын 21-ны өдрийн 57/04 дүгээр тогтоол гарсан боловч хэрэгжүүлээгүй байна.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэл 31,167.4 сая төгрөг, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн дуусаагүй үйлдвэрлэл данс 13,226.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба дансанд олон жил хуримтлагдсан, бичиг баримтын бүрдэл дутуу, шилжүүлэхэд бэлэн болсон хөрөнгийг бүртгэх талаар тодорхой шийдвэрт хүрээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8-д *“Төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах”* гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн оршин байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүд зөрчигдөх,

ҮАГ-ын зөвлөмж

Дуусаагүй үйлдвэрлэл дансанд удаан хуримтлагдсан үндсэн хөрөнгийг холбогдох байгууллагуудад шилжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 1-ний дотор ҮАГ-т ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

**3.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт
бичгийн талаар**

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Харилцаа холбооны зохицуулах хороо, Үндэсний "Дата" төв УТҮГ зэрэг байгууллагуудын НББ-ийн бодлогын баримт бичигт холбогдох хууль, дүрэм, журмын өөрчлөлтийг тусгаагүй, байгууллагын онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт, шинэчлэн боловсруулалт хийгээгүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т *"Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана"* гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын онцлогт тохируулан шинэчлэн баталж, мөрдөж ажиллах, биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 1-ний дотор ҮАГ-т ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, дансны бичилт, ангилал буруу хийсэн байх, дансны ангилал буруу байх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	/мян.төг/	
		2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		98,727,775.3	142,560,555.4
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	9,752,042.5	24,287,956.2
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	9,517,228.2	15,721,292.0
УРЬДЧИЛГАА	7а, 7б	5,059,561.4	7,282,904.8
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	74,398,510.8	95,260,828.9
НӨӨЦИЙН БАРАА	9а	432.3	0.0
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		0.0	7,573.5
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		98,239,664.8	260,736,738.9
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	98,239,664.8	260,736,738.9
Биет хөрөнгө		92,169,657.0	253,798,070.6
Биет бус хөрөнгө	13	6,070,007.7	6,938,668.2
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		196,967,440.1	403,297,294.3
НИЙТ ӨР ТӨЛБӨР		4,951,320.0	75,904,960.2
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	4,951,320.0	8,468,466.3
Өглөг	17а, 17б	4,860,568.3	5,567,762.1
Урьдчилж орсон орлого	18а, 18б	90,751.7	2,900,704.2
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19	0.0	67,436,493.8
Урт хугацаат зээл	20а, 20б	0.0	67,436,493.8
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		192,016,120.1	327,392,334.1
Засгийн газрын хувь оролцоо		192,016,120.1	327,392,334.1
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		69,764,737.6	63,527,455.3
Өмч /төрийн/ /ТӨҮГ/		0.0	123,192,740.3
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		0.0	116,214.3
Хуримтлагдсан үр дүн		115,308,731.7	131,668,227.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		6,942,650.8	8,887,696.2
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		196,967,440.1	403,297,294.3

4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мян.төг /

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		132,340,809.4	275,507,765.0
ТАТВАРЫН ОРЛОГО		0.0	32,645,461.9
Орлогын албан татвар		0.0	32,645,461.9
Хувь хүний орлогын албан татвар		0.0	32,645,461.9
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	54,492,130.9	74,006,993.5
Нийтлэг татварын бус орлого		39,083,859.0	73,377,831.0
Хөрөнгийн орлого		15,408,271.8	253,802.2
Тусламжийн орлого		0.0	375,360.2
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		77,848,678.5	168,855,309.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	127,748,827.9	146,606,542.3
УРСГАЛ ЗАРДАЛ		127,748,827.9	140,944,183.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		96,284,087.9	131,386,814.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		37,525,578.1	51,067,176.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,704,966.3	2,860,076.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		2,109,905.8	4,417,414.3
Хангамж, бараа материалын зардал		1,265,206.1	2,945,698.7
Нормативт зардал		633,557.0	680,950.5
Эд хогшил, урсгал засварын зардал		507,652.7	1,121,653.5
Томилолт, зочны зардал		848,267.4	790,699.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		8,425,985.9	14,303,256.4
Бараа үйлчилгээний бусад зардал		43,262,968.4	53,199,888.7
ТАТААС		1,067,319.7	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		30,397,420.2	9,557,368.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	5,662,358.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		4,591,981.4	128,901,222.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		101,543.0	885,659.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		3,006,667.2	8,333,911.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		1,686,857.2	121,452,971.0

4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	189,504,147.7		189,504,147.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-7,867,026.9		-7,867,026.9
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	181,637,120.9		181,637,120.9
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	49,692.3		49,692.3
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	8,642,449.7		8,642,449.7
Тайлант үеийн үр дүн	1,686,857.3		1,686,857.3
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	192,016,120.1		192,016,120.1
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	192,016,120.1		192,016,120.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	20,231,410.3		20,231,410.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	212,247,530.4		212,247,530.4
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-98,968.8		-98,968.8
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-6,261,559.9		-6,261,559.9
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	52,361.4		52,361.4
Тайлант үеийн үр дүн	121,452,971.0		121,452,971.0
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,392,334.1		327,392,334.1

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мян.төг /

Тайлангийн үзүүлэлт	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	117,697,644.5	260,966,893.2
ТАТВАРЫН ОРЛОГО	0.0	11,732,492.6
Орлогын албан татвар	0.0	11,732,492.6
Хувь хүний орлогын албан татвар	0.0	11,732,492.6
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,561,007.6	80,280,372.9
Нийтлэг татварын бус орлого	23,152,735.7	79,989,010.2
Хөрөнгийн орлого	15,408,271.8	253,802.2
Тусламжийн орлого	0.0	37,560.4
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	79,136,636.9	168,954,027.5
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	97,023,686.3	124,082,644.2
УРСГАЛ ЗАРДАЛ	97,023,629.1	124,082,644.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	65,640,314.8	104,234,450.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	37,570,628.7	52,406,528.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,741,672.7	4,370,528.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,172,579.2	8,758,598.1
Хангамж, бараа материалын зардал	1,090,156.0	3,097,318.4
Нормативт зардал	542,297.1	701,532.1
Эд хогшил, урсгал засварын зардал	644,861.7	1,378,223.5
Томилолт, зочны зардал	815,750.0	472,350.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,867,204.8	9,019,669.7
Бараа үйлчилгээний бусад зардал	15,195,164.1	24,029,701.1
ТАТААС	1,067,319.7	3,749,448.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,316,051.7	16,098,744.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	20,673,958.2	136,884,248.9
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	8,174.1
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	16,273,772.6	121,921,099.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,273,772.6	121,921,099.7
Дотоод эх үүсвэрээр	16,273,772.6	121,921,099.7
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-16,273,772.6	-121,912,925.6
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	44,223.0	-435,409.5
Бусад эх үүсвэр	0.0	154,889.6
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-44,223.0	590,299.2
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	4,444,408.6	14,535,913.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,307,633.8	9,752,042.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,752,042.5	24,287,956.2

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мян.төг /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	186,023,918.5	179,383,455.2	6,640,463.2	96.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	78,676,797.5	76,816,445.2	1,860,352.2	97.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70,613,735.8	69,086,774.8	1,526,960.9	97.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,619,199.9	38,189,886.4	429,313.4	98.8
210101	Үндсэн цалин	32,795,870.0	32,789,005.9	6,864.1	99.9
210102	Нэмэгдэл	3,275,945.5	3,338,625.8	-62,680.3	101.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,643,795.8	1,451,554.9	192,240.8	88.3
210105	Гэрээт ажлын хөлс	903,588.6	610,699.7	292,888.8	67.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,384,388.2	1,318,990.4	65,397.8	95.2
210201	Тэтгэврийн даатгал	499,257.0	516,230.9	-16,973.9	103.4
210202	Тэтгэмжийн даатгал	56,097.6	40,200.0	15,897.5	71.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	74,494.4	58,672.7	15,821.6	78.7
210204	Ажилгүйдлийн даатгал	14,013.1	14,125.9	-112.8	100.8
210205	Эрүүл мэндийн даатгал	740,526.1	689,760.8	50,765.2	93.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	949,487.7	926,642.3	22,845.3	97.5
210301	Гэрэл, цахилгаан	441,884.7	491,243.4	-49,358.7	111.1
210302	Түлш, халаалт	346,925.9	293,160.6	53,765.2	84.5
210303	Цэвэр, бохир ус	71,191.5	54,644.1	16,547.3	76.7
210304	Байрны түрээс	89,485.6	87,594.1	1,891.4	97.8
2104	Хангамж, бараа материалын зардал	1,007,065.8	973,133.9	33,931.8	96.6
210401	Бичиг хэрэг	163,094.6	205,052.1	-41,957.5	125.7
210402	Тээвэр, шатахуун	483,906.6	482,204.3	1,702.2	99.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	235,125.4	169,261.9	65,863.4	71.9
210404	Ном, хэвлэл	0.0	1,174.4	-1,174.4	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	23,746.7	20,444.9	3,301.7	86.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	101,192.5	94,996.0	6,196.4	93.8
2105	Нормативт зардал	630,951.4	576,861.8	54,089.5	91.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,480.0	5,862.9	1,617.0	78.3
210502	Хоол, хүнс	332,499.0	310,370.0	22,128.9	93.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	290,972.4	260,628.8	30,343.5	89.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	505,991.2	467,589.4	38,401.7	92.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	48,720.5	71,182.1	-22,461.6	146.1
210602	Тавилга	22,950.0	3,549.7	19,400.3	15.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,963.7	2,437.4	3,526.3	40.8
210604	Урсгал засвар	428,357.0	390,420.2	37,936.8	91.1
2107	Томилолт, зочны зардал	148,056.9	137,105.7	10,951.1	92.6
210701	Гадаад албан томилолт	0.0	61,861.6	-61,861.6	0.0
210702	Дотоод албан томилолт	103,779.7	39,689.8	64,089.8	38.2
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	44,277.2	35,554.2	8,722.9	80.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,921,866.4	1,387,234.8	534,631.5	72.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	944,565.3	535,157.3	409,407.9	56.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	263,500.0	159,024.4	104,475.5	60.3
210803	Даатгалын үйлчилгээ	43,926.4	44,488.3	-561.9	101.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	15,444.5	14,029.5	1,414.9	90.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,626.5	1,162.5	463.9	71.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	557,099.2	538,983.2	18,115.9	96.7

**Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210807	Газрын төлбөр	16,052.9	16,052.3	0.5	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,875.0	1,417.7	457.3	75.6
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	77,776.6	76,919.3	857.2	98.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,446,728.3	25,109,329.8	337,398.4	98.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,376,512.0	25,039,349.8	337,162.1	98.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	70,216.3	69,979.9	236.3	99.6
212	ТАТААС	6,026,876.0	5,994,324.7	32,551.2	99.4
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	2,244,876.0	2,244,876.0	0.0	100.0
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	2,244,876.0	2,244,876.0	0.0	100.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,782,000.0	3,749,448.7	32,551.2	99.1
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,782,000.0	3,749,448.7	32,551.2	99.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,036,185.7	1,735,345.6	300,840.1	85.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,082,395.4	1,077,517.9	4,877.4	99.5
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,082,395.4	1,077,517.9	4,877.4	99.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	953,790.3	657,827.6	295,962.6	68.9
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,860.4	9,449.0	8,411.4	52.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	935,929.9	648,378.6	287,551.2	69.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	107,347,121.0	102,567,010.0	4,780,110.9	95.5
220001	Барилга байгууламж	9,844,919.0	6,727,127.0	3,117,791.9	68.3
222001	Тоног төхөөрөмж	0.0	340,000.0	-340,000.0	0.0
223001	Бусад хөрөнгө	97,502,202.0	95,499,882.9	2,002,319.0	97.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	186,023,918.5	179,383,981.6	6,639,936.8	96.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	166,364,963.1	162,227,043.2	4,137,919.8	97.5
310001	Улсын төсвөөс санхүүжих	166,364,963.1	162,227,043.2	4,137,919.8	97.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	19,658,955.4	17,156,938.4	2,502,016.9	87.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,756,638.2	1,467,353.2	1,289,284.9	53.2
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,247,117.2	2,028,754.5	-781,637.3	162.6
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	0.0	5,652.0	-5,652.0	0.0
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	15,655,200.0	13,655,178.6	2,000,021.3	87.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	900.5	-900.5	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	1,427.0	-1,427.0	0.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,168.0	2,116.0	52.0	97.6
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.0	6.0	0.0	100.0
610001	Төсвийн байгууллага	6.0	6.0	0.0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	1,081.0	1,063.0	18.0	98.3
620001	Удирдах ажилтан	29.0	20.0	9.0	68.9
620002	Гүйцэтгэх ажилтан	859.0	844.0	15.0	98.2
620003	Үйлчлэх ажилтан	161.0	167.0	-6.0	103.7
620004	Гэрээт ажилтан	32.0	32.0	0.0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,081.0	1,047.0	34.0	96.8
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	179.0	162.0	17.0	90.5
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	528.0	528.0	0.0	100.0
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	28.0	28.0	0.0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	276.0	263.0	13.0	95.2
650010	Гэрээт ажилтан	70.0	66.0	4.0	94.2